



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2021 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА

ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, МӨНГӨН ОРЛОГО	2
ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, МӨНГӨН ЗАРЛАГА	6
ӨРХИЙН ЗЭЭЛ	12



Нэг өрхөд ногдох дундаж үзүүлэлтийг 2021 оны 2 дугаар улиралд “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд хамрагдсан 2803 өрхүүдийн сүүлийн 12 сарын орлого, зарлагыг сард шилжүүлэн нийт өрхөд тархаан тооцлоо.

Нэг өрхөд ногдох сарын дундаж орлого, зарлагыг тооцохдоо цалин хөлсний орлого болон хүнсний хэрэглээний зарлагаас бусад төрлийн орлого, зарлагын сүүлийн 12 сарын дунджаар тооцсон болно.

Өрхийн амьжиргаанд нөлөөлж байдаг гол хүчин зүйлийн нэг нь өрхийн орлого юм.

Өрхийн нийт орлогыг өрхийн мөнгөн орлого, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Өрхийн мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

Өрхийн нийт зарлагыг өрхийн мөнгөн зарлага, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.


Өрхийн мөнгөн зарлага нь хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусдад өгсөн бэлэг, тусламж, бусад зарлагаас бүрдэнэ.

ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, МӨНГӨН ОРЛОГО

Судалгааны 2021 оны 2 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 1.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 58.1 (3.9%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 92.8 (6.4%) мянган төгрөгөөр нэмэгджээ.


Өрхийн орлогын бодит өсөлтийг харахын тулд үнийн нөлөөллийг арилган тооцдог. Энэхүү тооцооллыг хийхдээ өрхийн орлогын мэдээллийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр засварлав. Тооцоогоор өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлогын хэмжээ 2021 оны 2 дугаар улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 29.4 (2.5%) мянган төгрөгөөр буурч, харин өмнөх улирлаас 27.8 (2.5%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 1. Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (мянган төгрөг), улсын дунджаар




Өрхийн сарын дундаж бодит нийт орлогын хэмжээ өмнөх улирлаас 2.5 хувиар нэмэгдэхэд тэтгэвэр, тэтгэмжийн бодит орлого 64.5 (22.9%) мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ (Зураг 1).

Зураг 2. Нэг өрхийн сарын дундаж нийт орлогын бүтэц (мянган төгрөг)




Зураг 3. Нэг өрхийн сарын дундаж нийт орлогын бүтэц (дүнд эзлэх хувь)



Улсын дунджаар 2021 оны 2 дугаар улирлын байдлаар өрхийн сарын дундаж нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 0.1 нэгж хувиар нэмэгдэж, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 0.9 нэгж хувиар буурсан байна (Зураг 3).

Өрхийн сарын дундаж нийт орлогыг хот, хөдөөгөөр нь авч үзвэл, хотод 1.6 сая төгрөг, хөдөөд 1.4 сая төгрөг байна. Хотын өрхүүдийн сарын дундаж нийт орлого хөдөөгийн өрхүүдээс 220.6 (15.8%) мянган төгрөгөөр их байна (Зураг 4).

Зураг 4. Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (мянган төгрөг), хот, хөдөө, бүс, суурьшлаар, 2021 оны 2 дугаар улирлаар




Өрхийн сарын дундаж мөнгөн орлого, оны үнээр 2021 оны 2 дугаар улиралд 1.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 66.1 (4.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Үүнд тэтгэвэр, тэтгэмжийн орлого 190.4 (70.1%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 12.8 (10.7%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлого өмнөх улирлаас 95.9 (7.2%) мянган төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэвэр, тэтгэмжийн орлого 100.0 (27.6%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 25.7 (24.2%) мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Нэг өрхийн сарын дундаж нийт орлого, улсын дунджаар


Орлогын төрөл	2020 IV-VI	2021		2021 IV-VI	2021 IV-VI
		I-III	IV-VI	2020 IV-VI	2021 I-III
	төгрөг			хувь	
Нийт орлого	1 484 800	1 450 065	1 542 867	103.9	106.4
1. Мөнгөн орлого	1 368 497	1 338 673	1 434 595	104.8	107.2
Цалин хөлс	750 722	687 108	650 458	86.6	94.7
Тэтгэвэр, тэтгэмж	271 633	361 999	461 989	170.1	127.6
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	119 375	106 388	132 126	110.7	124.2
ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	93 192	75 050	76 078	81.6	101.4
Бусад орлого	133 575	108 128	113 944	85.3	105.4
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	49 236	44 821	36 662	74.5	81.8
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	67 067	66 571	71 610	106.8	107.6

Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг бүтцээр нь авч үзэхэд, 2021 оны 2 дугаар улиралд цалин хөлсний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 9.6 нэгж хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 1.5 нэгж хувиар, бусад орлогын эзлэх хувь 1.8 нэгж хувиар буурч, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 12.4 нэгж хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь 0.5 нэгж хувиар өссөн байна (Зураг 6).

Зураг 5. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (мянган төгрөг)




Зураг 6. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц (дүнд эзлэх хувь)



Өрхүүдийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзэхэд 2021 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 300.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 20.4 мянгаар, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 2.4 мянгаар, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрх 0.8 мянгаар буурсан бол 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 5.1 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрх 2.0 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрх 1.7 мянгаар, 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрх 8.0 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн орлоготой өрх 9.5 мянгаар, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 8.8 мянгаар тус тус нэмэгдсэн байна (Зураг 7).

Зураг 7. Мөнгөн орлогын бүлэглэлт, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр




Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар сард 500.0 мянган төгрөг хүртэлх мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 7.6 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 71.2 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 11.7 хувь, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 2.1 хувь, бусад орлого 7.4 хувийг эзэлж байна (Зураг 8а).

Мөн сард 1.6 сая төгрөгөөс дээш мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзэхэд цалин хөлсний орлого 55.6 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 20.1 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 8.9 хувь, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 6.1 хувь, бусад орлого 9.3 хувийг эзэлж байна (Зураг 8г).


Зураг 8. Мөнгөн орлогын бүлэглэлтийн бүтэц, дүнд эзлэх хувь, 2021 оны 2 дугаар улирлаар

- Цалин хөлс
- Тэтгэвэр, тэтгэмж
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого
- Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого
- Бусад орлого


а. 500 000 төгрөг хүртэлх




б. 500 001 - 900 000 төгрөг



в. 900 001 - 1 600 000 төгрөг



г. 1 600 001 төгрөгөөс дээш




ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, МӨНГӨН ЗАРЛАГА

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2021 оны 2 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 1.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 65.7 (4.3%) мянган төгрөгөөр буурч, харин өмнөх улирлаас 16.7 (1.1%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 2021 оны 2 дугаар улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 124.8 (10.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 29.4 (2.6%) мянган төгрөгөөр буурчээ.

Зураг 9. Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага (мянган төгрөг), улсын дунджаар




Өрхийн сарын дундаж бодит нийт зарлагын хэмжээ өмнөх улирлаас 2.6 хувиар буурахад хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 35.7 (5.1%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 9).

Зураг 10. Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц (мянган төгрөг)




Зураг 11. Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь)



Улсын дунджаар 2021 оны 2 дугаар улирлын байдлаар өрхийн сарын дундаж нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувь 0.4 нэгж хувиар нэмэгдэж, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 0.7 нэгж хувиар буурсан байна (Зураг 11).

Өрхийн сарын дундаж нийт зарлагыг хот, хөдөөгөөр авч үзвэл, хотод 1.6 сая төгрөг, хөдөөд 1.3 сая төгрөг байна. Хотын өрхүүдийн сарын дундаж нийт зарлага хөдөөгийн өрхүүдээс 220.5 (16.6%) мянган төгрөгөөр их байна (Зураг 12).

Зураг 12. Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага (мянган төгрөг), хот, хөдөө, бүс, суурьшлаар, 2021 оны 2 дугаар улирлаар




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, оны үнээр 2021 оны 2 дугаар улиралд 1.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 57.7 (4.0%) мянган төгрөгөөр буурч, харин өмнөх улирлаас 19.8 (1.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар буурахад хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 84.3 (8.6%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага, улсын дунджаар


Зарлагын төрөл	2020 IV-VI төгрөг	2021		2021 IV-VI 2020 IV-VI хувь	2021 IV-VI 2021 I-III хувь
		I-III	IV-VI		
Нийт зарлага	1 542 040	1 459 591	1 476 318	95.7	101.1
1. Мөнгөн зарлага	1 425 737	1 348 199	1 368 046	96.0	101.5
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	313 310	306 764	339 642	108.4	110.7
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	977 253	905 858	892 959	91.4	98.6
Бусад зарлага	110 112	109 793	111 798	101.5	101.8
Бусдад өгсөн бэлэг, тусламж	25 062	25 784	23 647	94.4	91.7
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	49 236	44 821	36 662	74.5	81.8
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	67 067	66 571	71 610	106.8	107.6

Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг бүтцээр нь авч үзвэл, 2021 оны 2 дугаар улиралд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагын эзлэх хувь 0.1 нэгж хувиар буурч, харин хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувь 2.8 нэгж хувиар, бусад зарлагын эзлэх хувь 0.5 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 14).

Зураг 13. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц (мянган төгрөг)



Зураг 14. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц (дүнд эзлэх хувь)




Өрхийн хүнсний бүтээгдэхүүний сарын дундаж зарлагын 36.9 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 22.8 хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 12.2 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 7.8 хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал, 3.7 хувийг элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан эзэлж байна (Зураг 15).

Зураг 15. Хүнсний бүтээгдэхүүний зарлага (төгрөг), зарим нэр төрлөөр, 2021 оны 2 дугаар улирлаар




Мөн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 11.7 хувийг бэлэн хувцас, гутал, 8.8 хувийг тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ, 6.0 хувийг харилцаа холбооны үйлчилгээ, 5.9 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний зардал, 5.1 хувийг боловсролын зардал эзэлж байна (Зураг 16).

Зураг 16. Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага (төгрөг), зарим нэр төрлөөр, 2021 оны 2 дугаар улирлаар



Өрхүүдийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзэхэд 2021 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 300.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 0.6 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрх 6.6 мянгаар, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрх 10.2 мянгаар, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 5.6 мянгаар буурсан бол, 300.0-500.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 3.7 мянгаар, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 8.5 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 15.1 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 4.9 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 2.3 мянгаар тус тус нэмэгдсэн байна (Зураг 17).

Зураг 17. Мөнгөн зарлагын бүлэглэлт, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр




Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар сард 500.0 мянган төгрөг хүртэлх мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний бүтээгдэхүүний зарлага 34.9 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 47.7 хувь, бусад зарлага 14.9 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлага 2.5 хувийг эзэлж байна (Зураг 18а).

Мөн сард 1.6 сая төгрөгөөс дээш мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний бүтээгдэхүүний зарлага 20.8 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 71.4 хувь, бусад зарлага 6.3 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлага 1.5 хувийг эзэлж байна (Зураг 18г).


Зураг 18. Мөнгөн зарлагын бүлэглэлтийн бүтэц, дүнд эзлэх хувь, 2021 оны 2 дугаар улирлаар

- Хүнсний бүтээгдэхүүний зарлага
- Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага
- Бусад зарлага
- Бусдад өгсөн бэлэг, тусламж


а. 500 000 төгрөг хүртэлх




б. 500 001-900 000 төгрөг



в. 900 001-1 600 000 төгрөг




г. 1 600 001 төгрөгөөс дээш



ӨРХИЙН ЗЭЭЛ

Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар нийт өрхийн 51.2 хувь буюу 466.5 мянган өрх зээлтэй амьдарч байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.2 нэгж хувиар буурсан байна.


Зураг 19. Зээлтэй өрх (хувь), зээлийн төрлөөр



Нийт зээлтэй өрхийг зээлийн төрлөөр нь авч үзэхэд 209.0 (44.8%) мянган өрх цалингийн зээлтэй, 148.8 (31.9%) мянган өрх бусад төрлийн зээлтэй, 84.0 (18.0%) мянган өрх хэрэглээний зээлтэй, 70.4 (15.1%) мянган өрх орон сууцны зээлтэй, 57.4 (12.3%) мянган өрх тэтгэврийн зээлтэй байна (Зураг 19).


Зээлтэй өрхүүдийн сүүлийн 12 сард авсан зээлийн дундаж хэмжээг доорх зурагт харууллаа. Судалгааны 2021 оны 2 дугаар улиралд зээлтэй нэг өрх дунджаар 8.5 сая төгрөгийн зээл авчээ. Орон сууцны зээлийн дундаж хэмжээ 62.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.3 (22.1%) сая төгрөгөөр, хэрэглээний зээлийн дундаж хэмжээ 1.3 (18.1%) сая төгрөгөөр нэмэгдэж, харин тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 0.1 (5.0%) сая төгрөгөөр буурсан байна (Зураг 20).

Зураг 20. Сүүлийн 12 сарын хугацаанд авсан дундаж хэмжээ (мянган төгрөг)



Зээлийн эргэн төлөлтийг авч үзвэл, 2021 оны 2 дугаар улирлын байдлаар зээлтэй нэг өрх сард дунджаар 683.6 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд буцаан төлж, өмнөх оны мөн үеэс 71.3 (11.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Зээлийн төрлөөр нь авч үзвэл, орон сууцны зээлтэй өрх сард дунджаар 603.9 мянган төгрөгийг, цалингийн зээлтэй өрх 481.9 мянган төгрөгийг, тэтгэврийн зээлтэй өрх 309.0 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд төлж байна (Зураг 21).

Зураг 21. Зээлийн нэг сарын эргэн төлөлтийн зээлийн дундаж хэмжээ (сая төгрөг)



НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
ӨРХӨД СУУРИЛСАН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

.....оОо.....